

**МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ  
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

1.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрлчөн найруулах.

29.13.Хилийн боомтын захиргаа нь хилийн боомтод цацраг хими, биологийн осол болон хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, цар тахлын онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ хуулийн 29.9-д заасан чиг үүргээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

**Санал гаргасан:Төсвийн байнгын хороо**

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

**Санал гаргасан:Төсвийн байнгын хороо**

**“МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ  
БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАХ АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН  
ТОМЬЁОЛОЛ**

1.Тогтоолын төсөлд Засгийн газарт үүрэг болгосон доор дурьдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“1.2.Засгийн газраас дэвшиүүлсэн төсвийн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн төрийн албандаа ашиглаж байгаа суудлын автомашины ашиглалтад тавих хяналтыг сайжруулж, зэвсэгт хүчин, цагдаа, тагнуул, онцгой байдал, эрүүл мэндийн байгууллагаас бусад төрийн байгууллагуудын суудлын автомашины хэрэглээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр үе шаттай хэрэгжүүлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах;”

**Санал гаргасан:Төсвийн байнгын хороо**

2.Тогтоолын төсөлд Засгийн газарт үүрэг болгосон доор дурьдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“1.3.2022 оны төсвийн жилд төсвийн хөрөнгөөр дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа, бүтээгдэхүүний хэмжээг өмнөх оны хэмжээтэй харьцуулахад 2 дахин нэмэгдүүлэх;”

**Санал гаргасан:Төсвийн байнгын хороо**

3.Тогтоолын төсөлд Засгийн газарт үүрэг болгосон доор дурьдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“1.4.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, үнийн өөрчлөлтийн индексийг батлах;

1.5.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт магадлал хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, холбогдох саналаа 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө Улсын Их Хуралд танилцуулах;”

**Санал гаргасан:Төсвийн байнгын хороо**

4.Тогтоолын төсөлд Засгийн газарт үүрэг болгосон доор дурьдсан агуулгатай дэд заалт нэмэх:

“1.6.Монгол Улсын тухайн жилийн төсвийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх, хөгжлийн бодлогод нийцсэн, нотолгоо, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх;”

**Санал гаргасан:Төсвийн байнгын хороо**

**5.Тогтоолын төсөлд Засгийн газарт үүрэг болгосон доор дурьдсан агуулгатай дэд заалт нэмэх:**

“1.7.төсвийг төлөвлөх, шат шатанд өргөн мэдүүлэх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлж, ил тод, нээлттэй болгох;”

**Санал гаргасан:Төсвийн байнгын хороо**

**6.Тогтоолын төсөлд Засгийн газарт үүрэг болгосон доор дурьдсан агуулгатай дэд заалт нэмэх:**

“1.8.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлтийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, аудитын дүгнэлтэд дурдсан төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр электрон тамхинд онцгой албан татвар ногдуулах асуудлыг судлан үзэж, шаардлагатай бол холбогдох хуулийн төслийг боловсруулж 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.”

**Санал гаргасан:Төсвийн байнгын хороо**